ГОВЬСҮМБЭР АЙМАГ
# ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 02 өдөр Дугаар А/88 Шивээговь сум

Нийтийн эзэмшлийн орон сууцны
3 дугаар байрны техникийн давхрын
шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн
ажлыг хүлээж авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй “Нийтийн эзэмшлийн орон сууцны 3-р байрны техникийн давхрын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил”-ыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Л.Бадамханд (Засаг даргын орлогч)

Гишүүд:
Б.Дэлгэрдалай (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
Ш.Чинболд (Илчлэг-Шивээ ОНӨААТҮГ-ын захирал)
Д.Будсүрэн (Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)
А.Отгонтуяа (Орон нутгийн өмчийн газрын дарга)
Л.Одонтуяа (Архивын тасгийн дарга)
Т.Эрдэнэбаяр (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын Улсын байцаагч)

| | |
|---|---|
| | Д.Баттуул<br>(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн) |
| Хөндлөнгийн төлөөлөл: | А.Баасанхүү<br>(Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, хяналтын бүлгийн гишүүн) |
| Нарийн бичгийн дарга: | У.Наранчулуун<br>("Такамаса" ХХК-ийн Ус хангамжийн инженер) |

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй "Нийтийн эзэмшлийн орон сууцны 3-р байрны техникийн давхрын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил"-ыг хүлээн авч ашиглалтад оруулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг комиссын дарга (Л.Бадамханд)-д, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, эдийн засгийн төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Д.Баттуул)-д, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, үр ашгийг дээшлүүлэн, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг байгууллагын дарга (Ш.Чинболд)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ч.СУГАРМАА